



ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт, MNS ISO 15189:2024 (ISO15189:2022) стандарт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эрүүл мэндийн лаборатори-чанар, чадавхад тавих шаардлага” MNS ISO 15189:2024 (ISO15189:2022) стандартад нийцүүлэн лабораторийн шинжилгээг үнэн зөв, чанартай хийж гүйцэтгэн эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах, үйл ажиллагаандаа MNS ISO 15189:2024 (ISO15189:2022) стандартыг мөрдөх зорилгоор доор 19 журмыг хавсралтаар баталсугай. Үүнд:

- Бичиг баримтын бүртгэлийн хяналтыг зохицуулах журам ЛНТ-ЖУ-001
- Лабораторийн нэгдсэн тасгийн үйл ажиллагааны журам ЛНТ- ЖУ-002
- Нэгдсэн лабораторид нэвтрэх журам ЛНТ-ЖУ-003
- Шинжилгээний өмнөх үйл явцын журам ЛНТ-ЖУ-004
- Яаралтай шинжилгээ хийх, мэдээллэх журам ЛНТ-ЖУ-005
- Шинжилгээний үеийн үйл явцыг зохицуулах журам ЛНТ-ЖУ-006
- Шинжилгээний дараах үйл явцыг зохицуулах журам ЛНТ-ЖУ-007
- Аюултай болон сээрэмжлүүлэх хариу мэдээллэх журам ЛНТ-ЖУ-008
- Тоног төхөөрөмжийг сонгох, худалдан авах, шалгалт тохируулга, засвар үйлчилгээ хийх менежментийн журам ЛНТ-ЖУ-009
- Үл тохирлын бүртгэх, залруулах, сэргийлэх, сайжруулах ажиллагааны журам ЛНТ-ЖУ-010
- Сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам ЛНТ-ЖУ-011
- Санал гомдол шийдвэрлэх журам ЛНТ-ЖУ-012
- Чанарын хангалтын журам ЛНТ-ЖУ-013
- Био-аюулгүй ажиллагааны журам ЛНТ-ЖУ-014
- Эрсдэлийн удирдлагын журам ЛНТ-ЖУ-015
- Урвалж, оношлуур, хэрэгсэл хүлээж авах хадгалах журам ЛНТ-ЖУ-016
- Нэгдсэн лабораторийн хүсэлт гэрээнд дүн шинжилгээ хийх журам ЛНТ-ЖУ-017

1625011003

- Мэдээллийн аюулгүй байдлын журам ЛНТ-ЖУ-018
- Удирдлагын дүн шинжилгээ хийх журам ЛНТ-ЖУ-019

2.Дээрх журмуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Лабораторийн нэгдсэн тасаг (Б.Очирсүрэн)-д даалгасугай.

3.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэл зүй хариуцсан дэд захирал (Л.Дагвадорж)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирлын 2022 оны А/73 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ЗАХИРАЛ

Э.ГАЛБАДРАХ

